



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан хотын Тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-ын
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2023/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.open.audit.mn

Дархан сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас: 99036806 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК

Утас: 95112689 Цахим хаяг: tsebs.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	9
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
4. Аудитын тайлан	11
4.1. Ерөнхий зүйл	11
4.2. Материаллаг байдал	11
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	12
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. Аудитын илрүүлэлт	13
5.1 Залруулга	13
5.2 Төлбөрийн акт	13
5.3 Албан шаардлага	14
5.4 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	14



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089,
Цахим илүүдэл: darhanuul@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023-03-15 № 166
талбай _____ -ийн № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ нь тайлант онд 3,261,040.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,536,287.2 мянган төгрөгийн зардал гарган 1,275,246.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын тайлант 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 88.4 хувийн биелэлттэй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ нь байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 88.4 хувиар тайлагнасан байна.

009020762

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

1. Аудитын санал, дүгнэлт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	97,341,320.81
1.1.2	Дансны авлага		-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		-
1.1.4	Бусад авлага		-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		-
1.1.6	Бараа материал	762,800,098.46	874,322,480.23
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	762,800,098.46	971,663,801.04
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,848,908,155.80	15,753,380,548.03
1.2.2	Биет бус хөрөнгө	25,890,209,626.76	3,022,457,720.12
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	41,739,117,782.56	18,775,838,268.15
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	42,501,917,881.02	19,747,502,069.19
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	5,000,000.00	-
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр		

Дархан сумын "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,000,000.00	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,000,000.00	-
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	42,496,917,881.02	21,022,748,703.85
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	(1,275,246,634.65)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	42,496,917,881.02	19,747,502,069.20
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	42,501,917,881.02	19,747,502,069.20



2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		3,261,040,597.51
3	Нийт ашиг (алдагдал)		
4	Түрээсийн орлого		3,261,040,597.51
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		-
10	Ерөнхий ба удирдлагын зардал		-
11	Санхүүгийн зардал		4,536,287,232.16
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		
19	Орлогын татварын зардал		(1,275,246,634.65)
20	Татварын дараах ашиг (алдагдал)		
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		(1,275,246,634.65)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
	Бусад олз (гарз)		-
24	Орлогын нийт дүн		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20.... оны ...-р сарын ...-ний үлдэгдэл	42,496,917,881.02	-	42,496,917,881.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
3	Залруулсан үлдэгдэл	42,496,917,881.02	-	42,496,917,881.02
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт			

ДАА-2022/12/-НА-СТА-ОНА



Дархан сумын "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

7	Зарласан ногдол ашиг			
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	20... оны .. -р сарын .. -ний үлдэгдэл	42,496,917,881.02	-	42,496,917,881.02
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
11	Залруулсан үлдэгдэл	42,496,917,881.02	-	42,496,917,881.02
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(1,275,246,634.65)	(1,275,246,634.65)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт	(21,474,169,177.17)		(21,474,169,177.17)
15	Зарласан ногдол ашиг			-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	20... оны .. -р сарын .. -ний үлдэгдэл	21,022,748,703.85	(1,275,246,634.65)	19,747,502,069.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		3,143,597,097.51
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		3,143,597,097.51
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		3,046,255,776.70
	Ажиллагчдад төлсөн		1,168,295,164.50
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		313,792,209.50
	Бараа материал худалдан авахад төлсөн		
	Ашиглалтын зардалд төлсөн		200,669,679.10
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		773,982,848.50
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага		599,515,875.10
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		97,341,320.81
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		

ДАА-2022/12/-НА-СТА-ОНА



Дархан сумын "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		97,341,320.81
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		97,341,320.81

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны		Зөрүү	Хувь
			төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	м/төг				
2	Нийт орлого	м/төг	2,838,587.2	3,261,040.5	-422,453.3	114.88
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг			0.0	
3	Нийт зардал	м/төг	2,838,587.2	4,536,287.2	-1,697,700.0	159.81
	Үүнээс: а) борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг				
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг		-		
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг				
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	-	(1,275,246.7)	-	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ нь Дархан сумын оршин суугчид, иргэд, ААНэгж байгууллагуудтай хог хаягдал татан зайлуулах нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийх, гудамж

ДАА-2022/12/-НА-СТА-ОНА



талбайн гэрэл гэрэлтүүлэгийн эвдрэл гэмтлийг засварлах, ногоон байгууламжийн арчилгааг харицах гэсэн чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулдаг байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон сууцны 15,083 айл өрхийн хог хаягдал
- Гэр хорооллын 6,799 айл өрхийн хог хаягдал
- төсвийн болон бусад аж ахуй нэгж 920 байгууллагатай хог хагдал тээвэрлэх гэрээ хийж, татан зайлуулах, булж устгах үйлчилгээ үзүүлдэг байна.
- 60,134 мкв авто зам, 48,675 мкв явган зам, 263,535 мкв ногоон байгууламж, 204,744 мкв эзэнгүй талбай буюу нийт 1,120,211 мкв талбайн цэвэрлэгээ үйлчилгээ ногоон байгууламжийн арчилгаа тордолгоог хийдэг байна.
- Төв замын гудамжны 1080 гэрэл, 682 байрны 18,815 фасадны гэрэл, хороолол дундах 703 гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн 5688 гэрэл гэрэлтүүлэг, нийт 31.000 мянган гаруй гудамж талбайн гэрэлтүүлгийн эвдрэл гэмтэл болон засвар үйлчилгээ хийдэг байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 16 тогтоолоор нэг хоногийн үнэд өөрчлөлт орсон.
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам" хэрэгжиж эхэлсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ нь 2022 онд боловсруулсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашигласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн А/80 стандартыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,754.4 мянган төгрөгөөр буюу 46,4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын төлбөрийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	97,341.3	97,341.3
Авлага	-	-	-
Бараа материал	762,800.1	874,322.5	111,522.3
Үндсэн хөрөнгө	41,739,117.8	18,775,838.3	(22,963,279.5)
Нийт хөрөнгө	42,501,917.9	19,747,502.1	(22,754,415.8)
Өр төлбөр	5,000.0		(5,000.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	42,496,917.9	19,747,502.1	(22,749,415.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	42,501,917.9	19,747,502.1	(22,754,415.8)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 97,341.32 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 11,160.2 мянган төгрөгийн хог тээврийн хураамжийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүйтэй, 58,806.6 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг азын хөгжлийн буцалтгүй тусламжаар орж ирсэн дахивар бүтээгдээгдэхүүний тоног төхөөрөмж худалдан авалтыг хил хаалттай холбоотойгоор зарцуулж амжаагүй,

27,274.3 мянган төгрөгийн санхүүжилтийг цас хайлуулах, давс бодис худалдан авах байсан боловч барааны олдоцгүй байдлаас шалтгаалан зарцуулаагүй байна.

Бараа материал 111,522.38 төгрөгөөр нэмэгдсэн нь цаг үеийн зайлшгүй шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаанд хэрэглэсэн ба шаардах хуудсаар зарлагадаагүй, тухай эд хариуцагчид бүртгэлээр шилжүүлж, бараа материалын үлдэгдэлд бүртгэсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 56,705,697.5 мянган төгрөг үүнээс төсвийн хөрөнгөөр 32,331.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 5,498.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг дахин үнэлсэн, 3,651.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил мөн дахин үнэлгээнд хамруулсан, 1,537,902.1 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 531,836.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 23,578.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 111,209.6 мянган төгрөгийн ногоон байгууламж, 4,606,596.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, мөн тус газар нь 2022 оны 04 дүгээр сарын 18 ны өдрийн 15 дугаар тогтоолоор 2 хуваагдаж "Дархан хотын соёл амралтын" хүрээлэнд бүтэцийн өөрчлөлтөөр 2,306,910.1 мянган төгрөгийн барилга байгууламж, 2,559,987.3 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж, 372,072.3 мянган төгрөгийн ногоон байгууламж, 2,435,463.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 22,867,602.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө буюу /газар/-ыг Аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчийн тогтоол болон ОНӨГазрын даргын тушаалаар нийт 30,542,035.4 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Өр төлбөр 5,000.0 мянган төгрөг байсан бол 2022 оны эцэст 0 болж буурсан.

Хуримтлагдсан алдагдал 1,275,246.6 мянган төгрөг болж өссөн нь НААҮГ газар 2 байгууллага болон салсантай холбоотойгоор үүссэн байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Дархан хотын Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-н гүйцэтгэх дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гүйцэтгэлээр 3,261,040.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,536,287.2 мянган төгрөгийн зардал гарган, 1,275,246.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,838,587.2 мянган төгрөг зардал гаргахаас 3,143,597.0 болж, төлөвлөснөөс 305,009.8 төгрөг буюу 10.75 хувиар хэтэрсэн нь байгууллагын дансанд төвлөрсөн хог хураамжийн төлбөрийг өөрийн орлогоор бүртгэсэн, төсвийн орлогын дансанд шилжүүлсэн 270,655.4 мянган төгрөгийг байгууллагын зардал болгон бичилт хийсэнтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого, зарлагыг төлөвлөөгүй байх ба туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн зарцуулсан 34,467.2 мянган төгрөг байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан хотын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "ЦЭСБ Аудит" ХХК-ийн аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Т.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан хотын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг "ЦЭСБ Аудит" ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,143,597.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 31,435.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Дархан хотын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан байна.

Үүнд: Дараа жилийн төсвийн төсөл-2 удаа, Төсөвт байгууллагын батлагдсан төсөв, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт-2 удаа, Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт -1 удаа

Энэ нь Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг хэмнэх

Дархан хотын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.5.1 Завсрын аудитын талаар

"ЦЭСБ Аудит" ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 18-ны өдрийн 185 дугаар албан бичгээр "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" захидлыг хүргүүлсэн бөгөөд тус компанийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 197,246.1 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	3	197,246.1	1	197,246.1	100.0
Нийт дүн	3	197,246.1	1	197,246.1	100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь өөрийн дансанд төвлөрсөн Хог хаягдлын хураамжийг өөрийн орлогоор бүртгэж, Төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн дүнгээр зардлын дансанд бичилт хийж зардал нэмэгдүүлсэн байна.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Залруулга

Аудитаар нийт 29,075,088.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 775,645.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ИТХ-ын тогтоол гараагүйгээс гэх шалтгаанаар тайлагнаагүй.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд Соёл амралтын хүрээлэн рүү шилжүүлсэн 28,299,443.0 мянган төгрөгийн хөрөнгийг зардлаар бүртгэсэн.

Аудитаар нийт **5,238.5** мянган төгрөгийн зөрчил илэрч, **167.2** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **5,071.3** мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын цалинг бууруулаагүй, цалингийн суутгал хийхдээ 167.2 мянган төгрөгийг дутуу суутгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 167.2 мянган төгрөгийн цалинг төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалын худалдан авалт

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 4,831.0 мянган төгрөгийн сэлбэг, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хэрэгжилтийг хангах.

2. Байгууллагаас төлсөн НДШ

2.1 Илрүүлэлт: Цалин бууруулах сахилгын шийтгэлтэй албан хаагчийн цалинг бууруулаагүй, цалингийн суутгал хийснээр байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг 240.3 төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг ханган цалин бууруулах арга хэмжээ авч ажиллах.

3. Шилэн данс

3.1 Илрүүлэлт: Дархан хотын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дархан сумын "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруул вагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлогын дэлгэрэнгүй тайланд хөрөнгийг зардлаар бүртгэсэн	1	28,299,443.0					1	28,299,443.0				
Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийг тайлагнаагүй.	1	775,645.1					1	775,645.1				
Дүн	2	29,075,088.1					2	29,075,088.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тооцооллын алдаанаас цалин илүү олгосон	1	167.2	1	167.2								
Байгууллагын зардал нэмэгдүүлсэн	1	240.3					1	240.3				
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	4,831.0					1	4,831.0				
Дүн	3	5,238.5	1	167.2	-	-	2	5,071.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хэрэгжилт	1							1
Дүн	1							1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 05 дугаар сарын 15

Дугаар 60/01-21210583-ДАА-2023/12/НА-СТА-ТӨА

Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн "Дархан хотын тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сахилгын шийтгэлтэй албан хаагчдын цалингаас нийт 167,240.00 төгрөг суутган тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Суутган тооцоогүй 167,240.00 (Нэг зуун жаран долоон мянга хоёр зуун дөчин) төгрөгийг хавсралтад дурдсан албан хаагчдаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тсот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн "Дархан хотын тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат, ахлах нягтлан бодогч Б.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ЦЭРЭННАДМИД



009050278

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын
 оны дугаар сарын-ний өдрийн
 дугаар актын хавсралт

Сахилгын шийтгэлтэй ажиллагсдын цалингийн тооцоо

Сар	А.хаагчийн овог, нэр	Албан тушаал	/төгрөгөөр/							
			Ажлын х/цаг	Аж.сан х/цаг	Олгох цалин	Хийсгээрх цалин	Цалин бууруулан бодсон бол буурах дүн	Сахилгын шийтгал	Суутгасан хувь	Дутуу суутгасан сахилгын шийтгал
6	Буянтөр.Цэц	Хог тээврийн жолооч	20	20	680,000	920,000	184,000	136,000	20	48,000
6	Сүхээ.Цол	Хог тээврийн жолооч	20	19	646,000	755,500	151,100	136,000	20	15,100
6	Шинэжил.Сан	Хог тээврийн ачигч	20	18	549,000	719,600	143,920	122,000	20	21,920
6	Эрхэмбаяр.Дэм	Хог тээврийн ачигч	20	16	488,000	821,100	164,220	122,000	20	42,220
10	Эрдэнэбат.Зор	Газрын дарга	21	21	1,400,000		280,000	240,000	20	40,000
Дүн										
167,240										